



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 1/12

Номгон

Асран хамгаалагч тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5, 67 дугаар зүйлийн 67.1.1, Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 1.4, Засгийн газрын 2021 оны 159 дүгээр тогтоолын “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох” журмын 4.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн эрхийн байцаагчийн 23 дугаар дүгнэлтийг хэрэгжүүлэх зорилгоор О.Эрдэнэ-Очир (ВП13282716), О.Очирбат (ВП17302317) нарын хууль ёсны асран хамгаалагчаар Н.Оюунбаярыг 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн тогтоосугай.

2.Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэхийг асран хамгаалагч (Н.Оюунбаяр)-д үүрэг болгосугай.

3.О.Эрдэнэ-Очир, О.Очирбат нарт хувийн хэрэг нээж ажиллахыг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн эрхийн Улсын байцаагч (Б.Содончимэг), асран хамгаалагчийн үүргийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны өдөр Засаг даргад танилцуулж ажиллахыг Есөнбулаг багийн нийгмийн ажилтан (Ж.Нарангэрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (С.Батцэрэн)-д даалгасугай.

ДАРГА   Г.ОЮУНБАЯР